

Тарифт өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны “Тариф шинэчлэн батлах тухай” 2023 оны 98 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол шуудан ХК-ийн давамгайл байдлтай үйлчилгээний тариф”-н 1.Хотын доторх бичиг захидлын үйлчилгээний тариф, 2.Хот хоорондын бичиг захидлын үйлчилгээний тарифыг хавсралтаар өөрчлөн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 98 дугаар тогтоолын хавсралтын 1.хотын доторх бичиг захидлын үйлчилгээний тариф, 2.хот хоорондын бичиг захидлын үйлчилгээний тариф, 2013 оны 55 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан тарифын хязгаарт багтаан үйлчилгээний үнэ тарифыг тогтоох, үйлчилж эхлэхээс өмнө хэрэглэгчдэд мэдээлэх, бэлтгэл ажлыг зохион байгуулж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг Монгол Шуудан ХК-д зөвшөөрсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД:

Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

2024 оны сарын өдрийн
....тоот тогтоолын хавсралт

МОНГОЛ ШУУДАН ХК-ИЙН
ДАВАМГАЙ БАЙДАЛТАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ
/ДЭЭД/

1. Хотын доторх бичиг захидлын үйлчилгээ /НӨАТ-гүй/

Төрөл/жингийн шатлал			Тариф (Төгрөгөөр)
Аймаг, хотын дотор	Энгийн захиа	Ширхэг /100 гр хүртэл/	1,100
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Бүртгэгдсэн захидал	Ширхэг /100 гр хүртэл/	4,500
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Буухиа бичиг захидал	Ширхэг /100 гр хүртэл/	6,000
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	1,000

2. Хот хоорондын бичиг захидлын үйлчилгээ /НӨАТ-гүй/

Төрөл/жингийн шатлал			Тариф (Төгрөгөөр)
Хот хооронд	Энгийн захиа	Ширхэг /100 гр хүртэл/	1,500
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Бүртгэгдсэн захидал	Ширхэг /100 гр хүртэл/	6,000
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	500
	Буухиа бичиг захидал	Ширхэг /100 гр хүртэл/	10,000
		Дараагийн бүрэн ба бүрэн бус 100 гр тутамд	2,000